



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/451

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4 дүгээр хуралдааны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Тайваний хүүхэд гэр бүлийг дэмжих сангийн Монгол дахь төлөөлөгчийн газраас хандивласан хавсралт дахь 13 нэр төрлийн, 852 ширхэг цэцэрлэгийн хүүхдийн тоглоом, цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийн тээврийн зардалд 1 778 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүд зарцуулах 1 778 000 төгрөг /нэг сая долоон зуун далан найман мянга/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 4.3-д заасан “Чадварлаг багш, сурагч, оюутан” дэд хөтөлбөр, арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
09 дүгээр сарын 02-ны өдрийн  
А/451 дүгээр захирамжийн хавсралт



ТАЙВАНИЙ ХҮҮХЭД ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН МОНГОЛ ДАХЬ  
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРААС ХАНДИВЛАСАН ЭД ЗҮЙЛСИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барааний төрөл	Бараа, эд зүйлсийн нэрс	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Цэцэрлэгийн хүүхдийн тоглоом	Авиралтын шат	ком	12
2		Дүрстэй саад	ком	24
3		Тоглоомон хашаа	ком	12
4		Цагирагтай заан	ком	12
5		Соронзон тоглоом	ком	36
6		Машин	ш	36
7		Лего тоглоом	ш	36
8		Эвлүүлдэг тоглоом /puzzle/	хайрцаг	12
9		Тоо	ш	36
10		Үддэг тоглоом	ш	36
11	Цэцэрлэгийн хүүхдийн зөөлөн эдлэл	Хүүхдийн хөнжил	ш	200
12		Хүүхдийн цагаан хэрэглэл	ш	200
13		Хүүхдийн эсгий гудас	ш	200
НИЙТ ДҮН				852

-oOo-